

МОНГОЛ, АМЕРИК ХОЁР УЛСЫН ХАРИЛЦААНД МОНГОЛ ЛАМ НАРЫН ОРУУЛСАН ХУВЬ НЭМЭР

Д.Лувсанжамц (Гавж)
Гандантэгчэнлин хийд

Түлхүүр үг: Монгол лам, Дилов хутагт, дипломат харилцаа, Да лам Цэрэнчимэд, Богд, Мэй Улс.

Товч утга: Тус өгүүлэлд XIX зууны сүүл, XX зууны эхэн үед Монгол лам нар монголын нийгмийн “сэхээтний” давхаргыг бүрдүүлж байсан бөгөөд улсынхаа улс төрийн амьдралд идэвхитэй оролцдог, улс орны ирээдүйд санаа тавьдаг байсан тухай, ялангуяа Монгол Улсын гадаад бодлогыг боловсруулах, дэлхийн олон оронтой харилцах, дипломат харилцаа тогтооход чухал нөлөө үзүүлж байсан ба тухайлбал Монгол Улс АНУ-тай дипломат харилцаа тогтоох үндсийг тухайн үеийн эрдэм мэдлэгтэй, зэрэг мяндагтай лам нар тавьсан тухай баримт, судалгаанд тулгуурлан өгүүлэв.

* * * * *

Монгол Улс, АНУ хоёр улсын хооронд дипломат харилцаа тогтоосон 30 жилийн түүхийн эхлэл суурь, бэлтгэл нь даруй зуу гаруй жилийн өмнөөс тавигдсан гэж үзэж үндэстэй юм.

Хоёр улсын харилцаанд ялангуяа эхэн үеийн харилцаанд монголын хутагт хувилгаад, мэргэд лам нар чухал байр суурь эзэлдэг. Америк Монгол хоёр орны улс төр эдийн засаг, шашин, соёл, нийгмийн харилцаа чухам хэдий үеэс эхлэлтэйг баттай баримтаар нотлож амжаагүй¹ хэмээдэг ч Америкийн христын шашны номлогчид Хятадаар дамжин 1855 оноос Ар Монголд анх ирж нутгийн олонтой энгийн түвшинд харилцаж, өдөр тутмын аж ахуйн ажилд тус дэм хүргэн өөрсдөө хэл сурах зэргээр итгэлийг олж шашны номлолоо явуулдаг байсан талаар баримт үлджээ.

Буддын сургаал номыг сонирхон судалдаг америк эрдэмтэд², адал явдал, байгалийн элдэв сонин гайхамшигийг сонирхон судлаачид³, худалдаачид⁴ үлэмжхэн хувь нэмэр оруулсныг дурьдах хэрэгтэй.

¹ Монгол –Америкийн харилцааны түүхийн мөрөөр бэдрэхүй., Ж.Дашидаваа УБ.,2017

² Уллиам Вүүдвилл Рокхилл нь 1884-1895 оны хооронд Бээжинд АНУ-н дипломатчаар ажиллаж байхдаа Монгол, Төвдийн нутгаар аялж “Лам нарын нутаг” (1891), “Монгол, Төвдөөр 1891,1892 онд аялсан тэмдэглэл” (1894) номууд хэвлэн гаргажээ. 1913 онд Өргөөд айлчилж, Конгрессын номын сангийн монгол номын цуглуулгын эхлэлийг тавьсан байна. Түүний бэлэглэсэн ховор нандин гар бичмэл, бурханы шашны хөлгөн судар монгол хэл дээрх модон барын судар өдгөө ч тус номын санд хадаглагдсаар байна. Төвдийн Далай лам Монголд дүрвэж явахдаа төвд хэлээр ус цас шиг

Манж Чин улс өөрийн эрхшээлийн үед Монголын нутагт гадаадын иргэд ирэхийг нилээдгүй хугацаанд зөвшөөрдөггүй байснаа шашны номлогчид 1859 оноос хөл тавьж бүртгэгдсэн баримт манай түүхийн архивт⁵ тэмдэглэгдэн үлджээ.

Америк, Монгол хоёр улсын харилцаа үүсэх түүхэн нөхцөл. (1855-1911 он)

Хүрээний амьд Будда.

Дээр өгүүлсэн Богд Жавзандамба хутагттай 1899 анхлан уулзсан хүн бол Америкийн иргэн, уул уурхайн инженер, Херберт Хүүвэр (1847-1965) байлаа⁶. Тэрээр Бээжин-Хаалган- Хүрээ-Хиагтын чиглэлд төмөр зам тавих боломжийг судлах, алтны ордны илэрц газар хайн олохоор монголыг зорин ирсэн байв. Тэрээр хожим бичсэн “Адал явдал он жилүүд дурдатгал”-даа “Морин дэл дээр өнгөрүүлсэн эдгээр аялалын маань нэг нь Монголын их говийг туулан нийслэл Өргөө хүртэл үргэлжилж билээ. Тэрхүү аялалын нэгэн хэвийг уйтгартай байдлыг Хутагт лам буюу амьд Буддатай уулзсан уулзалт амь оруулсан юм. Үүнд Орос улс Манж Чин улсын хооронд байгуулсан гэрээний дагуу Оросын Тройцкавск-Хиагтаас Хятадын Хаалган буюу Бээжин, Оросын холбох холбооны шугамын ажлыг гүйцэтгэж байсан Швед инженер болон түүний найз Оросын консулаар дамжуулан Хутагт ламтай уулзсан⁷” хэмээн бичжээ. Энд өгүүлж буй инженер бол швед гаралтай Франц Август Ларсон бөгөөд тэрээр христос шашны номлогч багийн ахлагч америк бүсгүйтэй гэрлэн тус улсын иргэн болсон нь Хаалган Хүрээний хооронд шашин төрийн элдэв хэргээр зорчин монгол хэл сурч Жавзандамба хутагт болон төрийн дээд зиндааныхантай ойр танилцах боломжийг нээсэн байж болох юм. Ларсон Монголд 1893 онд анхлан ирж Жавзандамба хутагтад хэд хэд бараалхан хаа нэгтээ Америктай харилцаа тогтоохыг зөвлөдөг байжээ. Тэрээр хожим Америкийн ерөнхийлөгч болсон

ярьдаг америк дипломатичийн тухай сонсож холбоо тогтоон хожим 1908 онд Утайд анх уулзжээ. Рокхилл далай ламтай урт удаан хугацааны турш нөхөрлөжээ. Бага залуугаасаа буддизм сонирхон судалж 1880 онд “Уданаварга”, “Пратимошка” (Тарвачэнбо), Ангид тонилгогч судрыг францаар орчуулж байжээ.

³ Зууны эхэн үед АНУ-ын байгалийн түүхийн мүүсийн судлаачид зураглаачид Монголд ирж тухайн үеийн талаар баримтад киноны зураг авч үлдээжээ. Монгол дахь үлэг гүрвэлийн үлдэгдэлийн томордыг олж судлан нэрд гарсан Рой Чампэн Эндрюс (1884-1960) 1918 онд тусгай албаны хэргээр анх Хүрээнд ирж байжээ Р.Ч Эндрюс нь гадаад Монголыг хоцрогдмол алслагдсан газар бус харин эртний алдар түүхтэй орон гэдгийг дэлхий дахинд ойлгуулахад үнэтэй хувь нэмэр оруулсан хүн юм. 1919 онд Богд хаанд шилэн форд машин бэлэглэж байжээ.

⁴ Америкийн тэрбумтан Жон Рокфеллер 1839-1937 ийн 1863 онд байгуулсан тухайн үедээ дэлхийн хамгийн том шатахуун үйлдвэрлэгч “Standart oil company”-ийн салбар нүүс Монголыг бензинээр хангаж байжээ.

⁵ 1962 оноо с “Мэй улс буюу Америкийг иргэн овог нэрийг бичээгүй нэгэн хүнд хятадаар галиглан худам монгол бичгээр үйлдсэн “ниү” бичиг олгосон ...

⁶ Төв Азид Манж Чин улсын эзэрхийлэлд хоёр зуугаад жил болсон буурай Монгол орныг Америкт, Өрнөдөд таниулахад хожмоо АНУ-ын 31 дэх ерөнхийлөгчөөр сонгогдсон Херберт Хүүвэрийн зууны эхээр Монголд ирсэн явдал түүхэн ач холбогдолтой болсныг судлаачид дурьджээ. Монгол Америк орны төрийн тэргүүнүүд болох хувь заяа бүхий Богд Жавзандамба хутагт, Х.Хүүвэр нарын хооронд ямар сэдэвтэй яриа болсон нь одоогоор тодорхой бус байгаа аж.

⁷ Ж.Дашидаваа. Монгол, Америкийн харилцааны түүхийн мөрөөр бэдрэхүй., УБ., 2017

Херберт Хүүвэр болон америкийн нэрт хайгуулч Рой Чамлен Эндрюс, Оросын алдарт эрдэмтэн академич Н.К.Рерих нарын ахалсан шинжилгээний багийнханд зуучилж байсан байна. 1911 оны 7 дугаар сард Хүрээнд болсон лам, ноёдын нууц зөвлөгөөнийг “богдын гэрт болж, тэрээр уулзалтыг даргалжээ”⁸ хэмээн Бээжинд сууж байсан Америкийн элчин сайдын яамнаас Засгийн газартаа ирүүлсэн нот бичигтээ мэдээлснээс үзэхэд Хүрээний богд АНУ-ын анхаарлыг ямар нэг байдлаар татаж байсан нь илт.

Харилцаа тогтоох гэж идэвхийлэн оролдож байсан үе (1911-1921 он)

1. Богд Жавзандамба хутагт⁹

ХІХ зууны эцэс, ХХ зууны эхэн үеийн монголын түүхийн ээдрээтэй эгзэгтэй үед тэр үеийн ихээхэн боловсролтой манж түвд орос, хэл эзэмшсэн буддын гүн ухаан, ертөнцийг үзэх үзэл төлөвшсөн, орчлон хорвоогийн амьдрал тэмцлийг гүнд нь хүртэл ойлгосон хүмүүс бол буддын лам нар байв. Тэд манжаас элдэв эрх ямба горьдохгүй, алба гувчуур төлөхгүй тул ихээхэн биеэ даасан байдалтай нөгөөтэйгүүр сүсэг бишрэл ихтэй монголчуудын дэмжлэг нөлөөг туйлын ихээр өөрсддөө татсан хүмүүс байлаа. Богд гэгээнээ тойрон хүрээлсэн лам хуврагууд манжийн шинэ засгийн бодлогыг ээсэргүүцэн, он удаан жилийн манжийн талхидалтаас гарах зам бүхнийг эрэлхийлж байлаа.

⁸ Р.Болд. Монголыг тусгаар тогтнолын талаарх АНУ-ын үзэл хандлага, байр суурь, бодлого сэдэвд докторын диссертаци, 2007 он, 24 дэх тал

⁹ Монгол Улсын эзэн хаан, шашин төрийг хослон баригч хаан (1911-1921). Хэмжээт цаазат хаан (1921-24), Халхын шарын шашны тэргүүн VIII Богд Жавзандамба хутагт (1869-1924). Таван настайдаа Жавзандамба хутагтын хойд дүрээр тодорч Их хүрээнд иржээ. Түүнийг халхууд “монголд элэгтэй” болгон хүмүүжүүлжээ. Тиймээс тэр өөрийгөө Чингис хааны угсаа, Халхын Түшээт хаан Гомбодоржийн хөвүүн I Жавзандамбын хойд дүр тул Монголын төрийн хэрэг, хувь заяа өөрт нь хамаатай гэж үздэг байв. Манжаас тусгаарлан салах хэмээсэн Халхын ноёдын санаачилгыг эхнээс нь дэмжиж эл хэргээр хаант Орост элч зарж байв. Манжийн шинэ засгийн бодлогыг эсэргүүцсэн Халхын ноёд түүнийг тойрон хүрээлсэн бөгөөд Богд гэгээн монголчуудын дунд үлэмж нэр хүндтэй байснаа ашиглаж, “монгол овогтон бүгдээр нийлж нэгэн улс болон тогтнох” лүндэн буулгажээ. Халхын ноёд, лам нар Манжаас тусгаарлан улсын хаанд Богд гэгээнийг өргөн зөвлөхөөр хэлэлцэн тохирсон бөгөөд 1911.12.29-д Богд Жавзандамба хутагтыг Монгол улсын хаан, шашин, төрийг хослон баригч түмэн наст богд хаанаар өргөмжилсөн. Хятадад нийлэхийг ятгаж байсан Хятадын ерөнхийлөгч Юань Шикай-н ятгалга, сүрдүүлгийг Богд хаан эс зөвшөөрч, бүх монголчуудыг нэгтгэж нэгдмэл Их Монгол Улсыг сэргээн мандуулахыг зорьж байв. Түүний засгийн газрын сайдууд төрийн тусгаар тогтнолоо хүчирхэг улсуудаар хүлээн зөвшөөрүүлэхийг оролдож байсан боловч энэ оролдлого Хиагтын гурван улсын хэлэлцээрээр таслагдсан билээ. 1919 онд хятадууд цэргийг хүчээр монголын автономыг цуцлахад Богд хаан гарын үсэг зураагүй юм. Харин ч төрийн тусгаар тогтнолоо сэргээхийг эрмэлзэн АНУ, ЗОУ, Япон болон Колчакийн засгийн газраас тусламж дэмжлэг эрэлхийлж байсан хүмүүсийг дэмжиж байв. Тиймээс хятадууд дээрх хэрэгт сэжиглэн түүнийг баривчлан хорьжээ. 1921 оны хоёрдугаар сард Хүрээг эзлэн авсан Барон Унгерн монголын автономыг сэргээн мандуулснаа тунхаглаж Богд гэгээнийг Монголын хаан ширээнд залсан бол таван сарын дараа ардын намынхан Нийслэл Хүрээнд орж ирээд мөн л Богдыг хаанаар өргөмжилжээ. 1921.11.01-д Ардын засгийн газраас Богд хаантай “тангаргийн гэрээ” байгуулж хааны улс төрийн эрх мэдлийг хасч хэмжээт эрхтэй хаан болгожээ.

Чингисийн удмын Өндөр гэгээн Занабазарын хойд дүр учир өөрийгээ алтан урагт тооцож байсан Жавзандамба Хутагт Монголын төрийн хэрэг, ард олны хувь заяа өөрт нь туйлын хамаатай гэж үздэг байлаа.

Ингээд Европ тооллын нэгэн мянга ёсөн зуун арван нэгдүгээр он, Манж Чин улсын Хэвт ёсны гуравдугаар он, Монголын арвантавдугаар жаран, цагагчин гахай жилийн есний өдөр монголчууд тусгаар тогтнолоо албан ёсоор зарлан¹⁰ Богд Жавзандамба Хутагтыг хаанд өргөмжилөн, Улсын нэрийг Монгол, оны цолыг Олноо өргөгдсөн гэж нэрлэн Их Хүрээг улсын нийслэл болгов¹⁰.

Ар Монголын тусгаар тогтносон нь Алс Дорнотын нөхцөл байдалд ялангуяа Японы бодлогод өөрчлөлт үзүүлэх ихээхэн чухал үйл явдал болох учир АНУ анхааралтай ажиглаж Хүрээнд болж буй үйл явдлын талаар цаг алдалгүй мэдээлэл авч байлаа.

Бээжинд суугаа АНУ-ын элчин сайд Келхаун 1912 оны 1 дүгээр сарын 8 ны орой Вашингтонд илгээсэн цахилгаандаа Ар Монгол тусгаар тогтносныг яаралтай мэдэгджээ. Тусгаар тогтнолын өмнөх үүсэн гарах нөхцөл байдлыг өмнөөс тандаж байсан нь илт байдаг.

Богд Жавзандамба хутагт түүний тэргүүлж буй Монголын засгийн газар байгуулагдсан цагаасаа эхлэн өөрийн тусгаар тогтнолоо дэмжүүлэх, гадаадын хандлагыг өөртөө татах үүднээс хэд хэдэн алхам¹¹ хийж байсны нэг нь дэлхийн томоохон есөн гүрэнд хандан мэдээлэл гаргасан явдал юм.

Монголын засгийн газраас 1912 онд Монгол улс байгуулсан учрыг айлтган алсын Америкийн Гадаад хэргийн яамнаа бичиг илгээв. Уг бичигт: *“Эдүгээ манай Монгол Улс нийт бүхлээр эртнээс тогтносоор ирсэн өөрийн газар орон ба шажин суртгаал ёс журмыг алдах үгүйгээр сахих учир нэгэнт Манж улсаас салаад өөртөө тогтнож өөрөө эзэрхэх улс төр байгуулан халх монголын шарын шашны эзэн Жавзандамба лам юугаа Монгол улсын хаан эзэнд өргөмжлөн шашин төрийг хослон бариулаад Олноо өргөгдсөний тэргүүн он үүтгэсэн зэрэг явдлыг”* эрхэм улсын гадаад явдлын гадаад яамнаа мэдэгдэж, цаашид улс хоорондын гэрээ байгуулан худалдаа нэвтрүүлэн харилцаа тогтоох санал дэвшүүлсэн байна.¹² Богдын засгийн газраас бичиг хүлээн авснаа Орос Хятадын талд мэдэгдээгүй, захидалыг буцаагаагүй зэргээс үүдэн Богд хаант

¹⁰ О.Батсайхан.Монголын сүүлчийн эзэн хаан Богд Жавзандамба хутагт:Амьдрал ба домог.,УБ.,2014

¹¹ Монголын эзэн хаан Богд Жавзандамба Хутагтаас Япон улсын цог жавхлант эзэн хаанд илгээсэн захидал. Энэ талаар Танака хэмээх хүний бичсэн өгүүллийг Токиод суугаа АНУ-ын элчин сайд Ларс Вилсон АНУ-ын төрийн нарийн бичгийн даргад хүргүүлсэн нь эдүгээ АНУ-ын Үндэсний архивт хадгалагдаж байна.

¹² О.Батсайхан.Монголын сүүлчийн эзэн хаан Богд Жавзандамба хутагт:Амьдрал ба домог.,УБ.,2014

Монгол улс, АНУ хоёр албан ёсоор харилцаанд орсон¹³ болохыг доктор Р.Болд тэмдэглэжээ.

1912 оны 12-р сард Оросын эзэнт гүрний Гадаад хэргийн яамнаас Богд эзэн хааны нэр дээр Оросын эзэн хааны алтан гуутай хөргийг бэлэглэж, баяр хүргэсэн байна. Америкийн талаас монголчууд тусгаар тогтнолоо сэргээн бэхжүүлсний дараагаар дэмжин талархасан үг бичиг, түүхэн баримт хараахан олдоогүй байна.

Богд хаант Монгол улсыг хүлээн зөвшөөрч, Чин улсын задралыг дэмжих нь АНУ-ын Ази дахь бодлогын үндэс болох Хятадын газар нутаг, засаг захиргааны бүрэн бүтэн байдлыг хадгалах зарчимтай зөрчилдөж байв.

Монголын засгийн газраас Мэй улсын засгийн газарт 1914 оны 2-р сарын 29 нд гурав дахь удаагаа захидал илгээж, үүнээс өмнө Богд хаант Монгол улсын засгийн газраас олон гадаад их улстай гэрээ байгуулж, худалдаа нэвтрүүлэхээр хоёр ч албан бичиг явуулсан боловч Орос улсаас бусад нь хариу ирүүлээгүйг тэмдэглэжээ¹⁴.

Оросын талаас Монголын биеэ даах эрмэлзэлтэйг дэмжиж байснаас тусгаар тогтнох улс болохыг дэмжих сонирхолгүй мөн Монголд нөлөөгөө тогтоохоор нэгэнт их Британи, Франц, Японтой урьдчилан тохирсон энэ үест Богд Жавзандамба хутагт Монголын тусгаар тогтнолоо баталгаажуулах, гуравдагч хөрштэй болохыг эрмэлзсэн бодлого амжилтад хүрээгүй ч тухайн үед ийм алсын хараатай бодлого гаргах зориг зүрхтэй, нөлөөтэй хүн Хүрээний Богдоос өөр байсангүй.

2. Жалханз Хутагт Дамдинбазар¹⁵

Бололцоо олдвол Бээжингээс цааш дахин хэд алхаж Америк орох санаа өвөрлөсөн Жалханз хутагт Дамдинбазар 1919 оны 11 сарын 10 нд Бээжинд ирж Юан Шикайтай уулзжээ. Уулзалтын дараа өдрүүдэд АНУ-ын хэргийг түр хамаарагч Чарльз Тейннетэй уулзахдаа Америкийн тал Монголыг шууд хамгаалалтаа авах,

¹³ Монголын тусгаар тогтнол ба Америкийн нэгдсэн улс: Монголын тусгаар тогтнолын талаарх АНУ-ын үзэл хандлага, байр суурь, бодлого 1910-1973: судалгааны бүтээл., Р.Болд., УБ., Непко., 2008

¹⁴ Уг бичигт: Зүй нь манай улс урдаар хүн явуулж олон учрыг нэвтрүүлж, найрамдлын гэрээ байгуулваас зохих боловч гагцхин хэл мэдэхгүй, зам нэвтрүүлэхэд гачигдан бүхийгээс албаны тамгат бичиг үйлдэж эрхэм Мэй улсын засгийн газарт илгээв. Олдоос улс төрийн хэргийг хэлэлцэн чадах сайн хүн манай Нийслэл Хүрээнээ гэрээ байгуулан худалдаа нэвтрүүлж тус олгомог хэмээхээс гадна түр хариу ирүүлэхийг эрмэлзмой” гэжээ

¹⁵ Содномын Дамдинбазар (1874 – 1923) нь Жалханз хутагт Содномын Дамдинбазар нь 1874 онд Засагт хан аймгийн Цогт гүний хошуу буюу одоогийн Завхан аймгийн Нөмрөг сумын нутагт төржээ. 1921 оны 2-4 сард анх удаа Богдын зарлигаар Монгол улсын ерөнхий сайдаар томилогдог Монгол улсын тусгаарлах хөдөлгөөнд чухал үүрэг гүйцэтгэсэн, тав дахь ерөнхий сайд нь байв. Түүнийг мөн Барон Унгерний засгийн газар доор ерөнхий сайд байсан гэдэг боловч зарим эх сурвалжууд Дотоод явдлын сайд байсан хэмээн заадаг. Барон Унгерн фон Штернбергийн Азийн морин дивиз Нийслэл хүрээг гамингаас чөлөөлөн Богд хаант Монгол улсыг дахин сэргээн 1922 оны 3 сарын 3-нд ерөнхий сайдаар хоёр дахиа томилогдон ажиллаж байгаад 1923 оны 6 сарын 23-ны өдөр аян замд явж байгаад нас баржээ

Монголын ашиг сонирхолыг төлөөлж Хятадын засгийн газартай ярилцах санал тавьж, Хүрээнд Америкийн консул томилуулж өгөхийг хүссэн Богд гэгээний захидлыг гардуулжээ. Энэ нь цаг хугацааны хувьд генерал Сүй Шүжан Хүрээнд ирж түйвээсний дараахан байлаа. Хэргийг түр хамаарагч Чарьз Тенней Тяньжинд сууж буй ерөнхий консул Эбэрхардыг Ар Монголын байдлыг тандуулахаар Хүрээнд 1920 оны 4-р сард илгээсэн байна¹⁶. Эбэрхард Жалханз хутагт, Дилав хутагт нартай уулзахад тэд Монголын өмнөөс Хятадын засгийн газартай ярилцах, Монголыг өмгөөлөлдөө авах хүсэлтээ тавьсан байна.

Автономит засаг унахаас өмнө зөрчилдөж автономийг болзолтойгоор буулгах болсон ноёд лам нарын санал гадны дэмжлэг авах асуудлаар бас л хоёр хуваагджээ. Жалханз хутагт, Дилав хутагт нар алсын Америкаас тусламж хүсэх саналтай байсныг Богд гэгээн дэмжсэн байна. Жалханз хутагт Хятадын ерөнхийлөгч Да Цзүнтанд Богд гэгээний захидалыг хүргэх дашрамд АНУ-аас тусламж дэмжлэг хүсч Богдын айлтгалыг АНУ-ын элчин сайдад гардууснаараа Монгол, Америкийн харилцааны түүхэн дэх төрийн түвшний албан ёсны анхны төлөөлөгч болсон хэмээн зарим судлаачид тэмдэглэжээ¹⁷.

1921 онд консул Сокобинийг Богдын хэд хэдэн удаагийн хүсэлтээр шийдсэн байна. Дайн болж байсан тул Хаалган очоод шууд Хүрээ явах асуудал хойшлогдсон байна. Сокобин Хүрээнд 1921 оны 8-р сарын 8 наас 9-р сарын 14 хүртэл сар орчим ажиллах үест Богд гэгээн ерөнхий сайд Д.Бодоогоор дамжуулан “Хятад Монголын хэлэлцээрт АНУ гарыг үсгээ зурж нэгдэн орох, ингэснээр Хятад, Монголын харилцаанд Хаант Оросын гүйцэтгэж байсан үүргийг АНУ авахыг “-ыг хүсэлт болгож байжээ. Сокобин тэмдэглэлдээ “Богд гэгээн энх амгалан байдлыг тогтоох талаар сэтгэл үлэмж зовниж, бие төлөөлөгч хэд хэдэн удаа илгээж, Монгол, Хятадын хоорондын хүнд байдалд зуучлахыг хүссэн болно” гэжээ¹⁸.

1922 оны 5 дугаар сарын 17-нд Р.Эндрюсийн экспедицид зөвшөөрөл өгсөн хэлэлцээрт Ерөнхий сайд Жалханз хутагт Дамдинбазар гарын үсэг зурж олгохдоо Р.Эндрюсд их элсэн цөлийн говиос “үлэг хорхой” гэгчийг олж ирэхийг даалгаж байсан ажээ.¹⁹

3. Да лам Цэрэнчимэд²⁰

¹⁶ Монголын тусгаар тогтнол ба Америкийн нэгдсэн улс: Монголын тусгаар тогтнолын талаарх АНУ-ын үзэл хандлага, байр суурь, бодлого 1910-1973: судалгааны бүтээл., Р.Болд., УБ., Непко., 2008

¹⁷ Ж.Дашидаваа. Монгол, Америкийн харилцааны түүхийн мөрөөр бэдрэхүй., УБ., 2017

¹⁸ Монголын тусгаар тогтнол ба Америкийн нэгдсэн улс: Монголын тусгаар тогтнолын талаарх АНУ-ын үзэл хандлага, байр суурь, бодлого 1910-1973: судалгааны бүтээл., Р.Болд., УБ., Непко., 2008

¹⁹ Ж.Дашидаваа. Монгол, Америкийн харилцааны түүхийн мөрөөр бэдрэхүй., УБ., 2017

²⁰ Монгол Улсын төрийн нэрт зүтгэлтэн, тусгаар тогтнолын төлөө, Манжийн дарлалын эсрэг тууштай тэмцэгч, Богд хаант Монгол Улсыг үүсгэн байгуулагч гол удирдагчдын нэг, Монгол улсын шадар сайд, бүгд захирах сайд, Дотоод Яамны хэргийг Бүгд Захиран Шийтгэгч яамны тэргүүн сайд Да лам Цэрэнчимэд юм. Чингэхийн учир юу хэмээвээс тэрбээр өдгөөгийн дэлхийн хамтын нийгэмлэгийн бүрэн эрхт гишүүн, ардчилсан Монгол Улсын тусгаар байдлыг XX зууны

АНУ-ын засгийн газарт хүргэх Богд хааны тамгатай бичгийг Богд хаант Монгол улсын дотоод хэргийг бүгд захиран шийтгэгч яамны тэргүүн сайд Да лам Цэрэнчимэд 1912 оны 12 дугаар сарын 13-нд Харбинд суугаа Америкийн консул Мэйнардад гардуулсан нь Богд хаант Монгол улс, АНУ хоёрын улс төрийн албан ёсны харилцааны нэгэн үйл явдал болжээ.

Энэ талаар Харбинд суугаа АНУ-ын консул Мэйнард Богд гэгээний тусгай даалгавараар Да лам Цэрэнчимэд Харбин, Хайлаараар ирж Японы орон нутгийн төлөөлөгчидтэй уулзан Монгол, Японы хооронд гэрээ байгуулах бодолтой байгааг урьдчилан Вашингтонд мэдэгджээ.

Энэ талаар АНУ-ын 28 дахь ерөнхийлөгч Вүүдров Вильсон 1913 оны 4-р сард ар Монголын тусгаар тогтнолыг Орос улс зөвшөөрснийг буруутган Богд хаант Монгол улсын саналд татгалзсан хариуг хэвлэлийн хуралд хэлсэн үгээрээ мэдэгдсэн юм.

Хэдийгээр их гүрнүүдийн тавьсан саадын улмаас бүтэлгүй болсон ч Алс Дорнодын олон улсын харилцаанд Монгол улс оролцох гэсэн оролдлого хийж байснаараа Да ламын айлчлал чухал ач холбогдолтой юм.

Ар Монголын тусгаар тогтнолыг АНУ зөвшөөрөхгүйг “нээлттэй хаалганы бодлого-“ыг үндэслэгчийн хувьд Рокхилль²¹ сайн мэдэж байсан учир 1913 онд Хүрээнд дахин ирэхдээ Жавзандамба хутагттай уулзахаар төдийлэн хүч тавиагүй байж болох юм. Харин Да лам Цэрэнчимидтэй уулзсан нь хожим монголын ноёд лам нар Хятад, Оросын 1913 оны тунхаглалд дургуйцэж буйг тодорхойлсон зэрэг хэд хэдэн дүгнэлтээс нь үзэхэд илэрхий байна.

Богдын засгийн газар Хиагтын гурван улсын гэрээ хэлэлцээ эхлэхийн өмнө гадаад гүрнүүдээр хүлээн зөвшөөрүүлэх дахин нэг оролдлого хийжээ. Бээжинд суугаа АНУ-ын элчин сайдын яаманд 1914 оны 6-р сарын 1нд Ф.А. Ларсоноор

эхэнд дахин сэргээсэн 1911 оны үндэсний хувьсгалын тулгын чулууг тавилцаж, тогтыг түшицлэсэн томоохон зүтгэлтэн байлаа. Г.Цэрэнчимэд нь 1872 онд Их шавийн нутагт (одоогийн Төв аймгийн Лүн сум) хүй тасарч, хүмүүн заяа залгажээ. Тэрээр удалгүй Дээрх яамны бичээч, ахлах бичээч, XX зуун гарахад Да ламын тушаалд дэвшин ажилласан байна. Манжийн «Шинэ засгийн бодлого» идэвхжсэн үед Да лам Цэрэнчимэд нэгэн санаа зорилго бүхий Чин ван Ханддорж, өвөрлөгч түшмэл Хайсан нартай илүү дотночлон нөхөрлөж, эцсийн их хэргийг бүтээхээр аминчлан хэлэлцэж эхэлжээ. Чин ван Ханддорж, Да лам Цэрэнчимэд нар санаачлан, 1911 оны VII сард Богд гэгээнд бат оршил өргөхөөр ирсэн Халхын дөрвөн аймгийн хан, чуулган дарга, жанжин хэбэй, хутагт хувилгаад зэрэг ихэс дээдсийг цуглуулж, үндэсний тусгаар тогтнол, эрх чөлөөний тэмцэлд эрслэн босох асуудлыг хэлэлцүүлжээ. Да лам Цэрэнчимэд нар Хаант Орост очсон хэргээ хязгаарлагдмал хэмжээнд бүтээн, Чин улсын хатуу чанд мөрдөлт мөшигөлтөөс болж, орос эмчийн дүрд хувиран нууцаар хил давж орж иржээ. Халхын Хүрээний Бүх Хэргийг түр Ерөнхийлөн Шийтгэх газрыг байгуулалцаж, түүний бүрэлдэхүүнд орж ажиллан, үндэсний хувьсгалыг бэлтгэн явуулахад зүтгэсэн юм. 1911 оны Монголын үндэсний эрх чөлөөний хувьсгал ялан мандаж, үндэсний тусгаар тогтнолоо дахин сэргээжээ. 1911 оны XII сарын Богд хаан төрийн яамдыг зэрэглэж, Дотоод яамыг тэргүүн яам болгож, Г.Цэрэнчимэдээр Засгийн газрын хэргийг бүхэлд нь эрхлүүлэх болсон байна.

²¹ АНУ-аас Манж Чин улс, Орос болон Константинольд сууж байсан Элчин сайд, нэрт дипломатич, монгол, Төвдийг судлагс эрдэмтэн Уиллиам Вүүдвилл Рокхилл 1854-1914 Америкийн “Азийн нийгэмлэг”-ийн хүсэлтээр Хятадад явах замдаа Оросын дорнод Сибирийн төмөр замаар зорчин Ар Монголд 1913 оны 12-р сарын 9-15 ны хооронд зочилж байжээ. Тэрээр “Ар Монголын автономитыг хадгалах явдал бол түүний төлөөх Орос, Чин улс хоёрын өрсөлдөөнийг шийдвэрлэх арга юм байна” гэж үзэж байв.

дамжин ирсэн Богдын захидалд АНУ өөрийн төрийн нарийн бичгийн дарга Брайны зааварласнаар эелдэгээр татгалзсан хариу өгчээ²².

Монгол улсын хойшдын хувь заяанд ихээхэн уршигтай баримт бичиг бол “Хятад, Орос, Монгол гурван улсын Хиагтын 1915 оны гэрээ” гэгч байлаа. Орос Хятад хоёр улсын шахалтаар 1911 онд тунхаглан зарласан тусгаар тогтнол, бие даасан байдлаа хязгаарлуулж “автономит улс” болж өвөр Монголыг Хятадад алдсан ч дотоод бодлогын талаар хараат бус тусгаар улсын бие даасан байдлаа хадгалах олон улсын эрх зүйн баталгааг арайхийн авч үлдсэн цаг үе байлаа.

4. Дилав Хутагт Жамсранжав²³

Автономит засаглалтай Богдын засгийн газар бие даан улс төрийн гадаад бодлого явуулах эрх хэмжээ хязгаарлагдмал байсан ч дэлхийн томоохон гүрнүүдийн өмгөөлөл эрэлхийлж өөрийн засгийн газрын эх оронч шадар түшмэд элч нарыг Дундад иргэн улс болон бусад улсад илгээж байсны нэг нь Дилав хутагт Жамсранжав юм. 1919-1920 оны эрс өөрчлөлт түүхэн үйл явцын өрнөлт, Монгол улс цаашид орших эсэх нь асуудал тулгарсан эгзэгтэй хүнд нөхцөлд Хятадын эрхшээлээс ангижран салж, автономит засаглалын эрхээ сэргээн тогтоохын төлөө тууштай тэмцэж явсан төр шашны зүтгэлтэн билээ.

АНУ-аас Тяньжинд суугаа ерөнхий консул дипломатч Чарьз Эберхардыг 1920 оны 4-р сард Хүрээнд ирэхэд Америкаас тусламж хүссэн Богд хааны тамгатай бичгийг гардуулан өгч байснаа Дилав хутагт “Ар Монголыг дурдатгал” номондоо дурсчээ. Дилав Хутагт 1920 онд Америкын цэргийн атташегийн туслах Филлонтон уулзжээ.

²² Монголын тусгаар тогтнол ба Америкийн нэгдсэн улс: Монголын тусгаар тогтнолын талаарх АНУ-ын үзэл хандлага, байр суурь, бодлого 1910-1973: судалгааны бүтээл., Р.Болд., УБ., Непко., 2008

²³ Б.Жамсранжавыг онд Диловын тавдугаар хойд дүрээр тодруулжээ.. Энэ үеэс түвд хэл сурч, зургаатайдаа 3000 шоголтой ном тогтоож байжээ. Долоон насандаа түвд номоо монгол руу орчуулж. 12-тойдоо түвдээс монгол руу, монголоос түвд рүү судар чөлөөтэй орчуулах болжээ. Долоо настайдаа равжун, 21-тэйдээ гэцэл сахил, 25-тайдаа цорж, 29 насандаа самади багш цол хүртжээ. Богд хааны тамгатай тусламж гүйх тухай бичгийн эхийг Жалханз хутагттай зохиосон байна. 1911 оны үндэсний эрх чөлөөний хувьсгалын удирдагчдын нэг тэрээр Баруун хязгаарыг тохинуулахад онцгой үүрэг гүйцэтгэжээ. Дотоод яамнаас Банчин богд, гоминданы Хятад, Өвөр Монголд нэвтэрч байсан япончуудыг тагнуулахаар Дилов хутагтыг өмнө зүгт илгээсэн байна. Өмнөд нутагт тэрбээр Банчин богд, Чан Кайши, Далай лам тэргүүтний дэргэд шадарлаж байхдаа Америкийн монголч эрдэмтэн О.Латтимортон танилцсан нь түүний амьдралын шинэ үеийг нээсэн байна. Нэр хүндтэй эрдэмтний урилгаар Америкд морилж, Жонс Хопкэнсийн их сургуулийн Монгол судлалын тэнхэмд багшлах болжээ. Энэ хоёр их хүн амьдралынхаа сүүлчийн өдөр хүртэл дотно нөхөрлөж, хамтран ажилласан байдаг. Хожим Нью-Жерси мужид Халимагуудын байгуулсан буддын сүмийн хамба болжээ. 1960 онд Дилов хутагт “Монгол бусад тусгаар тогтносон улс гүрний адил НҮБ-д бие даасан гишүүн байж болно” хэмээн Чан Кайшигээр хүлээн зөвшөөрүүлж чадсан нь түүний түүхэн гавьяа билээ. 1965 оны дөрөвдүгээр сарын 7-нд Нью-Йорк хотод насан эцэслэжээ.

Хаалган дахь Консулын газрын дипломатич Самуэл Собокин ардын хувьсгалын дараа 1921 оны 8-р сарын 18 ны өдөр Нийслэл хүрээнд ирж Богд хаанд бараалхажээ.

Богд хаан консул Собокинтай уулзаад *“Хутагт миний бие шашны тэргүүн агаад Монгол улсын хаан тул Төрийн хэргийг манай Ардын засагтай хэлэлцэх буй заа, Сүсэгтэн олны хувьд миний бие амьд бүхнийг хайрлаж, манай Монгол нь Хятадтай эв дүйгээ ололцон олон түмэн харилцан дайсагналгүй, зовлон шаналагүй байхыг туйлаас хүсэх тул Нэгдсэн улсын хүндэт ноён Та тус хоёр орны түмний тусын тулд боломжит бүх замыг сүвэгчилнэ гэдэги бат итгэж байна. Америкийн Нэгдсэн Улс Монголыг тусгаар тогтнолыг хүлээн зөвшөөрсөн анхны улс болно гэдэг мөн итгэж байна”* гэж айлджээ.

Собокин хэд хэдэн удаагийн айлчлал, лам нар ноёдтой уулзаж байсан зэрэг удаан хугацааны ажиглалтаараа *“монголчууд бол өөрийн түүх соёлтой, хятадаас огт өөр үндэстэн юм байна”* гэж дүгнэн бичсэн байна.

Америкаас дайжсан үе. (1922-1945 он)

1912-1924 онд Монголыг засгийн газар нь АНУ-ын засгийн газарт хандаж найрсаг харилцаа тогтоох, харилцан худалдаа хийх, элчин консул суулгах зэрэг саналыг идэвхитэй тавьж байжээ.

1924 онд Богд таалал болж ардын засгийнхан Зөвлөлт Орос улсын коммунист нам, коминтерний төлөөлөгчидын оролцоотойгоор засгийн хэлбэрийн асуудлыг хуулчилан хоёр орны худалдаа арилжаа эрс багассаар 1930-аад оны эхээр Монгол дахь Америкийн худалдааны ашиг сонирхол бүрэн зогсчээ.

1925 оны 9-р сарын 23 нд хуралдсан МАХН-ын 4-р их хурлаар *“харъяат улсын хар шар харгисуудын үлдэгдэлийг бүрмөсөн арилгах”* зорилт гарч Богдын хойд дүрийн асуудал болон лам нарын үйл үйлдэл илт хумигджээ.

XX зууны эхэн үеэс хүчирхэгжсэн томоохон орнууд дэлхийн газар нутгийг дахин хувааж эзэмшихээр булаацалдаж хоёр тэнхлэгт хуваагдан улмаар 1914 онд дэлхийн I дайн, 1942 онд II дайн эхэлж, улс орнуудын харилцан ойлголцох нөхцөл боломж хумигдсанаас Монгол, Америк хоёр орны хооронд дипломат харилцаа тогтоох хүртэл олон арван жил өнгөрсныг²⁴ судлаачид өгүүлжээ.

Дэд ерөнхийлөгч Хэнри Уоллес Гандан хийдэд

Америкийн Нэгдсэн Улсын 33 дахь дэд ерөнхийлөгч Хэнри Агард Уоллес (1888-1965) БНМАУ-д 1944 онд албан ёсны айлчлал хийжээ.

Хэдийгээр дэд ерөнхийлөгчийн айлчлал богино хугацаанд болоод өнгөрсөн ч уг айлчлал нь Монголын Бурхан шашны түүхэнд чухал ач холбогдолтой байсан гэдгийг тэр үед тийм ч олон хүн мэдэлгүй өнгөрсөн юм.

Уоллес богино хугацааныхаа айлчлалын үеэр Богд хааны зуны ордон болон Гандан хийдэд зочилжээ. Орос-Америкийн зураач, зохиолч, их сэтгэгч Николай Рерихтэй дотно нөхөрлөн, дорно дахины шашин шүтлэгийг ихээхэн сонирхдог дэвшилтэд үзэлтэй хүний хувиар Монголд орныг шамбалын орон хэмээн сэтгэж лам хувраг сүм хийдийг үзэхийг санал болгосон бололтой байдаг.

²⁴ Ж.Дашидаваа. Монгол, Америкийн харилцааны түүхийн мөрөөр бэдрэхүй., УБ., 2017

Энэ үед шашны эрх чөлөөт улс харагдахыг хичээн Эрдэнэпил хамба тэргүүтэй долоон ламыг цуглуулан Мөргөлийн сүм нэртэйгээр Гандан хийдийг хурал номыг эхлүүлжээ.

Энэ айлчлалд америкийн нэрт эрдэмтэн, гадаад бодлогын зөвлөх, монгол хэл соёлыг сонирхон судлагч О.Латтимори хэлмэрч ирсэн бөгөөд Дилав хутагт Богд гэгээнтэний орон хийд, хурал номын өргөө ямархан байгааг нүдээр үзэхийг захисан байх тун магадлалтай.

О.Латтимор дэд ерөнхийлөгчийг даган 1944 онд Хятадад очихдоо Дилав хутагттай уулзаж, Монголын нөхцөл байдлыг ярилцсан байна. Дилав хутагт Чунцины засгийн газарт шүүмжлэлтэй хандаж, өвөр Монголчууд Хятад, Японоос хөндийрч ар Монголтой нэгдэх хандлагатай болж байгааг ярьсан нь Уоллесийн Рузвелтэд явуулсан илтгэлд нөлөө өгсөн байж болно. Энэ үед Ар Өвөр Монгол нэгдвээс байдал ихэд дордох тул БНМАУ-ын тусгаар тогтнолыг зөвшөөрсөн нь илүү дээр хэмээн Сталин Сунд анхааруулсан байна

Харилцаанд өөрчлөлт гарсан үе. (1945-1961 он)

Дэлхийн энх тайван, аюулгүй байдлыг сахин хангах үүрэгтэй НҮБ-ын гишүүнээр БНМАУ элсэх өргөдөлөө 1946 онд өгч 1948, 1956, 1957 онд сэргээж байжээ. Энэ талаар АНУ нь Гоминданы засгийн газрын байр суурийг харгалзах байдалд 1947 оноос шилжсэн байна²⁵. Ерөнхийлөгч Кеннеди 1961 оны зун, намар удаа дараалан БНМАУ-ын олон улс дахь байр суурь бэхжиж байгаад тун дурамжхан байсан Чан Кайшид явуулсан гурван ч захидалдаа БНМАУ-ын НҮБ-д элсэх асуудалд хориг тавихгүй байхыг хүссэн байна.

НҮБ-ын Аюулгүйн зөвлөлийн есөн гишүүн БНМАУ-ыг НҮБ-ын гишүүнээр элсэх зөвлөмжийг дэмжсэн санал 1961 оны 10-р сарын 25 нд өгч БНМАУ нь НҮБ-ын гишүүн болжээ. Санал хураалтад АНУ түдгэлзэж, Тайвань оролцоогүй байна.

Монголын тусгаар тогтнол ба Америкийн нэгдсэн улс номд *“Америкийн тал БНМАУ-ыг НҮБ-ын гишүүнээр элсүүлэх явдлыг Чан Кайшигаар зөвшөөрүүлж Тайваны хоригийг зайлуулав”* хэмээн бичснээс үзэхэд юутай ч Дилав хутагтыг энэ талаар Чан Кайшид нөлөөлсөн хэмээдэг нь оргүй бус бололтой. Дилав хутагт Гоминданы засгийн газарт Чан Кайшигийн дэргэд зөвлөхөөр ажиллаж байсан тухай намтарт нь гардаг билээ. Дилав хутагтын шадар нөхөр О.Латтимор Гоминданы засгийн газарт улс төрийн зөвлөхөөр ажиллаж байсан ба Дилав хутагтын үзэл бодлыг дэмждэг хүний хувьд тун байж болохоор магадлал юм.

НҮБ-ын гишүүнээр элссэн нь Монголын эрх зүйн статусын талаарх эргэлзээ тасарч, АНУ-ын дотоодод ялангуяа Конгрессын байр суурийг нааштайгаар өөрчлөхөд хүргэжээ.

Өмнөх үеийн дээдэс лам нарын үйлс зохионгуйг ном тэмдэглэлээс үзсэн дуулснаа нэгтгэн тэмдэглэхийн зэрэгцээ Америк, Монгол хоёр улсын түүх судлал,

²⁵ Монголын тусгаар тогтнол ба Америкийн нэгдсэн улс: Монголын тусгаар тогтнолын талаарх АНУ-ын үзэл хандлага, байр суурь, бодлого 1910-1973: судалгааны бүтээл., Р.Болд., УБ., Непко., 2008

соёл боловсролд хувь нэмрээ оруулсан олон монгол хуврагууд тухайлбал америкийн буддизмын эцэг хэмээгдэж буй хуруу дарам цөөн томоохон эрдэмтэн мэргэдийнх нь багш торгууд Гэвш Ванжил, Ар халхын Очирдарь хувилгаан, Бэрклийн их сургуулийн олон эрдэмтэн профессоруудтай мөр зэрэгцэн алхаж явсан монгол хувраг зүүн Сөнөдын Да лам Намжилдорж²⁶, Дилав хутагтын шавь Жамбалдорж лам, Төвд-Монголын соёлын төвийн тэргүүлэн яваа Ажаа гэгээнтэн нарын олон эрдэмтэн хувраг лам нарын оруулсан хувь нэмрийг ч дурдаад дуусашгүй байна.

Нэг талаас XIX зууны дунд үеэс Мэй улсын зүгээс нээлттэй хаалганы бодлого явуулахын өмнөхөн алс дорнод руу идэвхитэй явуулах болсон христийн номлогчид²⁷ нөгөө талаас Манжийн дарлалыг түлхэн унагаахыг завдан буй Жавзандамба Хутагт тэргүүтэй халхын томоохон лам нар хоёр улсын эхэн үеийн харилцааны түүхэн нөхцөл байдалд нөлөөлсөн гэж үзэх үндэстэй юм.

Буддын шашны гүн ухаан, хүний сэтгэлийг татах эрдэм чадал түүнийг эзэмшсэн, түүнийг сонирхон судалдаг хүмүүсийн ер бусын харилцаа хоёр улсын ард түмний нийгэм соёлын харилцаанд нөлөөлж, улс төрийн аливаа нөхцөл байдлаас дээгүүр байж түүхийн аль ч цаг үест тасраагүй байсныг цохон тэмдэглэх хэрэгтэй.

ҮIII Богд Жавзандамба хутагтын харилцаа бол Монгол улс тусгаар тогтнолоо сэргээн мандуулсны дараагаар улс улстай, гүрэн гүрэнтэй харилцах томоохон дипломат харилцаа, ялангуяа гуравдагч хөршийн харилцааны суурийг тавих үйлс байсныг олон улсын харилцааны түүхэнд хүндэтгэн үзэх учиртай.

Монголын тусгаар тогтнолын талаар 1914 оны эхний хагаст дэлхийн томоохон гүрнүүд Англи, Америк, Франц, Герман улсуудын парламент болон засгийн газрын түвшинд ямар нэг хэмжээгээр авч хэлэлцэхэд хүрсэн²⁸ нь Жавзандамба хутагт, Жалханз Хутагт С.Дамдинбазар, Да лам Г.Цэрэнчимэд, Дилав хутагт Б.Жамсранжав нарын зүгээс дэлхийн олон улсад хандаж явуулсан гадаад бодлого, хүчин чармайлтын тодорхой нэг үр дүн мөн.

²⁶ Зүүн Сөнөд хошууны Зараа сүмийн Да лам Намжилдорж нь 1965-1968 онуудад Америкийн Баруун эргийн их сургууль (University of California Berkeley) шашины гүн ухаан зааж байгаад 1968 онд хүндээр өвчилж 1969 онд University of California, San Francisco (UCSF) эмнэлэгт таалал төгсчээ. Тэрээр Дилав хутагтын нутгаасаа Халхын хурлаас авч гарсан гарын шавь байсан ба Энэтхэгт төвд ном хэвлүүлж байгаад Дилав хутагтын бие муудахад 1965 онд АНУ-д дуудагдан ирсэн байна. Түүнийг Нью Жерсид байхад нь Жэймс Боссон багш очиж уулзаад сургуульдаа урьж ажиллуулжээ. Америкийн олон эрдэмтэн профессоруудтай 60-аад онд эгэл сайхан монгол хувраг мөр зэрэгцэн алхаж явсныг энэхүү зураг гэрчилж байна. Ш.Баатар

²⁷ АНУ Бээжинд элчин сайдын яамаа 1860 онд нээсэн бөгөөд Манж Чин улсад христийн шашны төлөөлөгчдийг ирүүлж суурьшуулах явдал Америкийн дипломатчуудын нэг үүрэг байсан Р.Болд., "Рокхилл ба гадаад Монголын асуудал"

²⁸ Монгол улсын эзэн хаан Жавзандамба хутагтаас Япон улсын Цог жавхлант эрхэмсэг эзэн хаанд илгээсэн захидалын талаар тодруулж үзвэл, Монгол улсаас тухайн үед зөвхөн Япон төдийгүй АНУ, Англи, Герман, Франц зэрэг улсуудад захидал илгээснийг мэдэж болохоос гадна тэдгээр орнуудын засгийн газар Монголын асуудлыг тодорхой хэмжээнд хэлэлцэж, өөр хоорондоо харилцсаныг харж болохоор байна.... Монголын сүүлчийн эзэн хаан Богд Жавзандамба., О.Батсайхан., стр 436

НОМ ЗҮЙ

1. Монголын тусгаар тогтнол ба Америкийн нэгдсэн улс: Монголын тусгаар тогтнолын талаарх АНУ-ын үзэл хандлага, байр суурь, бодлого 1910-1973: судалгааны бүтээл., Р.Болд.,УБ.,Непко.,2008.
2. Монголыг сүүлчийн эзэн хаан Богд Жавзандамба: амьдрал ба домог О.Батсайхан., Улаанбаатар .,2014.
3. Орос, Монгол, Хятад: Улс төр дипломатын харилцаа., Т.Төмөрхүлэг., УБ., 2016.
4. Олон улс судлал сэтгүүл., МУ-ын ШУА-ын олон улс судлалын хүрээлэн, УБ 2005.,
5. АНУ-ын монгол судлаачид., М.Саруул-Эрдэнэ.,УБ.,2015.
6. Ж.Дашдаваа. Монгол, Америкийн харилцааны түүхийн мөрөөр бэдрэхүй., УБ.,2017.
7. Primary source material on Mongolia's history (1911-1924) from the US national archives, Washington, DC
8. The impact of China and Russia on United States-Mongolian political Relations in the twentieth century ., Alicia Campi and R.Baasan The Edwin Mellen press,Ltd. 2009.
9. The Dilov Khutugt of Mongolia., Ulaanbaatar .,2009
10. Jonathan S. Addleton.,U.S.-Mongolia diplomatic relations: a most helpful factor.,1978-2012.

ABSTRACT

High ranked Mongolian holy lamas, spiritual leaders and prominent monks played a historic role during early encounters involving Mongolia and the United States. Exact dates marking the start of political, economic, cultural and social relations between the two countries are not entirely clear. However, with respect to religious connections, there is evidence that the first American Christian pastors and priests to visit Outer Mongolia arrived via China in 1855, bringing their holy books and theological teachings with them²⁹.

The historical connections have played out in both directions, on the one hand involving Christian missionaries³⁰ assuming an active role in East Asia just prior to the Open Door Policy from the mid-nineteenth century and, on the other hand, prominent lamas headed by Javzandamba Khutagtu working to overthrow the Manchu Dynasty regime in Mongolia and then reaching out to other countries including the United States, eventually resulting in further engagement between the two countries.

²⁹ Ж.Дашдаваа. Он цагийн дурдатгал., УБ., 2017

³⁰ АНУ Бээжинд элчин сайдын яамаа 1860 онд нээсэн бөгөөд Манж Чин улсад христийн шашны төлөөлөгчдыг ирүүлж суурьшуулах явдал Америкийн дипломатчуудын нэг үүрэг байсан Р.Болд., “Рокхилл ба гадаад Монголын асуудал”

The Mongolian National Archives³¹ contains evidence relating to visits by early Christian missionaries, including the granting of “travel passes” to them in 1859, even though during the Manchu period foreigners had not been permitted to set foot in Mongolia.

Only eleven years before Mongolia became an independent country, a Living Buddha Javzandamba Khutaght and Herbert Hoover, then a young engineer based in China and later President of the United States, met each other. Apparently Larson, the Swedish missionary who later became a businessman and still later an American citizen himself and was widely known as the “Duke of Mongolia,” helped connect them and possibly translated for them. Later in 1913, Herbert Hoover travelled to Urga and met Da Lam Tserenchimed, a student of the Bogd Khan.

Mongolia proclaimed independence on December 29, 1911, naming Ikh Khuree (Urga) as capital of the newly sovereign country³². The American Ambassador in Beijing, then known as Peking, apparently sent a telegram to Washington to inform his superiors of Mongolia’s independence.

According to Mongolian records, in 1912 the Mongolian Government headed by the Bogd Khan sent messages to the State Department in Washington, DC, also affirming Mongolian independence. However, there is no evidence in terms of historical documentation on the American side to confirm (or deny) these accounts in which Mongolian officials reached out to the United States to proclaim Mongolia’s new status as an independent country.

In 1919, Jalhanz Hutagtu Damdinbazar, Mongolia’s Minister of Foreign Relations, delivered two letters affixed with the Bogd Khan’s stamp to the temporary United States Consul, offering him permanent status in Ikh Khuree. Also, he signed permission papers for at least one of the Roy Chapman Andrews expeditions, discussing with Andrews his quest for dinosaur fossils in the Gobi.³³

In 1920, Dilow Khutagt and Jalhanz Hutagtu again officially asked Consul Eberhardt to work toward the establishment of formal diplomatic relations between the United States and Mongolia.

The visit of the American Vice President Henry Wallace (who served under President Franklin Roosevelt) to Ulaanbaatar in 1944 marked the high point of interaction between the United States and Mongolia during the first half of the twentieth century. Wallace’s historic trip included a visit to Gandaan Monastery.

According to some accounts, Wallace – who was definitely interested in eastern religions at a time when the Mongolia government in Ulaanbaatar followed Stalin’s atheistic inclinations and actively worked to suppress Buddhism – helped preserve

³¹ 1862 оноос “Мэй улс буюу Америкийг иргэн овог нэрийг бичээгүй нэгэн хүнд хятадаар галиглан худам монгол бичгээр үйлдсэн “шу” бичиг олгосон ...

³² Ш.Нацагдорж. Манжийн эрхшээлд байсан үеийн Халхын хураангуй түүх, УБ.,1963., 268 дахь тал

³³ Ж.Дашидаваа. Он цагийн дурдатгал, УБ.,2017

Gandaan Monastery by expressing an interest in Mongolia's Buddhist heritage and requesting an audience with leading Mongolian religious figures³⁴.

In 1949, the well known American Mongolist Owen Lattimore invited Dilov Khutagtu from Tibet³⁵ to come to America. Ochir Dari gegeen who was the teacher of Dilav Khutagtu also came to America, an interesting if little known historical encounter involving both the US and Mongolia

In 1949 Dilov Hutagt's student, Lama Jambaldorj (1909-2011) who was invited to America from India to look after his teacher, thus becoming the second Mongolian lama to come to America. After Dilov Khutagt's death in 1965, he established a new Nitsan temple in memory of his esteemed teacher in 1973. Later the Lama Yondonjamts, the friend of Jambaldoorj, also settled in the United States.

Geshe Wangyal (1902-1983) arrived in the United States in 1955, founding a Buddhist monastery open to Americans. Many of his earliest students including Dr. Robert Thurman, Dr .Jeffrey Hopkins, Dr. Alexander Berzin, etc. have become leading Buddhist scholars, teachers, and practitioners.

Da Lam Namjildorj, a student of Dilov Hutagtu, came to America and taught Buddhism at the University of California, Berkeley between 1965 and 1998.

Arjia renpoche, head of Gumbum temple, arrived in the United States in 1998.

It is important and even inspiring to remember how such high ranked Mongolian lamas and prominent monks contributed to the political, educational, and religious relations between the United States and Mongolia, establishing the foundations for mutually beneficial interactions that continue to this day.

³⁴ Jonathan Addleton. *Mongolia and the United States: A diplomatic History*